

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ТЭТГЭВЭР,
ТЭТГЭМЖИЙН ХЭЛТСИЙН ТЭТГЭВРИЙН ТОГТООЛТ, ОЛГОЛТ
ХАРИУЦСАН БАЙЦААГЧ Б.УУГАНЦЭЦЭГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН
ЭЦСИЙН АЖЛЫН ТАЙЛАН**

ЧДНДГ-т тэтгэврийн байцаагчаар 2024.1.1 ээс 2024.10.22-ний өдрөөс хойш ажилласан. Томилогдон ажилласан хугацаанаас эхлэн нийт 1513 даатгуулагчийн мэдээллийг шинээр мэдээллийн нэгдсэн санд оруулан тэтгэврийг бодож олгосон ба Үүнд:

Өндөр насны тэтгэвэр тогтоолгохоор хүсэлт гаргасан 2586 даатгуулагчийн мэдээллийг мэдээллийн нэгдсэн санд оруулан 499 500 000 төгрөгийн тэтгэврийг жагсаалтаар олгосон.

Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгохоор хүсэлт гаргасан 108 даатгуулагчийн мэдээллийг мэдээллийн нэгдсэн санд оруулан 70 200 00 төгрөгийн тэтгэврийг жагсаалтаар олгосон.

Тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгохоор хүсэлт гаргасан 73 даатгуулагчийн мэдээллийг мэдээллийн нэгдсэн санд оруулан 39 985 000 төгрөгийн тэтгэврийг жагсаалтаар олгосон.

Тэтгэврийн тусгай зохицуулалтын хуулийн дагуу хүсэлт гаргасан 39 тэтгэвэр авагчийн мэдээллийг мэдээллийн нэгдсэн санд оруулан олголтыг хуулийн хугацаанд тухай бүр олгосон.

Давхардсан тоогоор өндөр насны тэтгэвэр тогтоолгосноос хойш ажилласан жилийн нэмэгдэл нэмүүлэх хүсэлт гаргасан 1296 даатгуулагчийн тэтгэврийн өөрчлөлтийг мэдээллийн нэгдсэн санд оруулан 716 492 538 төгрөгийн нэмэгдлийг тухай бүр олгосон.

Давхардсан тоогоор хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагч 627 даатгуулагчийн ЭХМК-н шийдвэрийг үндэслэн ХЧА-ны хугацааны сунгалтийг хийн тэтгэвэр олголтыг тухай бүр олгосон.

Нийт 104 тэтгэвэр авагчийн нас барсан хөдөлгөөнийг хийж нас барсны дараа сарын тэтгэвэр олголтын жагсаалтыг тухай бүр сангийн нягтлан бодогчид хүргүүлсэн.

Байгууллагаас зохион байгуулсан албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх танхимын болон цахим сургалтууд болох:

- 2024.03.21-нд НДЕГ-аас Цахим мэдээллийн цагаар “Байгууллага хувь хүний санхүүгийн төлөвлөлт, удирдлага” сэдвээр zoom-ээр сургалт зохион байгуулсан.
- “Төрийн албаны үнэт зүйл, үе хоорондын ялгаатай байдал” сэдвээр Монгол Улсын Их сургуулийн Улс төр судлал, олон улсын харилцаа,

нийтийн удирдлагын сургуулийн ахлах багш доктор (Ph.D) Г.Мягмар явуулна.

- 2024.04.08 “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян-2024” арга хэмжээг Олон улсын хөдөлмөрийн байгууллагын уриатай уялдуулан “Уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд эрүүл, аюулгүй хөдөлмөр эрхэлцгээ” уриан дор зохион байгуулахтай холбоотой сарын аяны нээлтийн арга хэмжээ өнөөдөр МҮЭСТО-нд zoom-ээр орсон
- Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024 оны 03- дугаар сарын 29-ны өдрийн “Хаврын их цэвэрлэгээ” нэгдсэн арга хэмжээ зохион байгуулагдаж байгаа тул 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр 17.00 цагт ажил тараад бүх албан хаагчид цэвэрлэгээнд оролцов
- Төрийн албаны зөвлөлийн өнөөдрийн 7:4:10 вебинар сургалт 10:00-11:00 цагт “Монгол төрийн зүтгэлтний хэв шинж -XX зууны эхэн хагас” сэдвээр Чингис хаан музейн захирал, академич С.Чулуун явуулав
- 2024.04.12-ны “Мэдээллийн цаг”-ийг СОНХАГ-аас хариуцан зохион байгуулж, Одон орон геофизикийн хүрээлэнгийн Астрометрийн судалгааны лабораторийн Эрдэм шинжилгээний ажилтан Ж.Амарсайхан “Одон орны сонирхолтой үзэгдлүүд” сэдвээр сургалт зохион байгуулав.
- 2024.04.15-ны Газрын сургалтын төлөвлөгөөний дагуу өнөөдөр 17.00 цагт Хүүхэд гэр бүлийн хэлтсийн мэргэжилтэн Х.Шүрэнцэцэг, Н.Нармандах нар “Өдөр тутамд хэрэглэгдэх хүмүүжлийн эерэг аргууд” сэдвээр сургалтанд суув.
- 2024.04.19-ны “Төрийн албан хаагч нарт зориулсан эх хэл, бичгийн мэдлэг, чадвар, дадлын номын танилцуулга”-ыг ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн захирал, доктор, профессор Ж.Бат-Ирээдүй, “Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа”-ны явцын талаар Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа нар явуулна.
- 2024.04.23 -нд “Эрүүл зөв хооллолт, амьдралын зөв хэв маяг” сэдвээр сургагч багш М.Баярцэцэг сургалт явуулав.
- 2024.05.09-ны Төрийн албаны үр ашгийг илэрхийлдэг олон улсын “InCiSE” индексийн хүний нөөцийн удирдлагын үзүүлэлтээр БНСУ олон улсад дээгүүр байр эзэлдэг байна. Тиймээс тус улсын төрийн албан хаагчдын сонгон шалгаруулалтын үйл явц, онцлог, туршлагаас Монгол улсын Төрийн албаны зөвлөлийн гишүүн Д.Баатарсайхан танилцуулсан ба zoom-ээр оролцов.
- 2024.05.16-нд “Төрийн албаны шинэтгэл ба цэгцрэх хөдөлгөөн” сэдвээр, 10:00-11:00 цагт Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар хүндэт зочноор оролцож, Монгол Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа “Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгаа” сэдвээр тус тус мэдээлэлийг тус тус zoom-ээр зохион байгуулсан сургалтанд оролцов.
- 2024.05.25-нд Автомашингүй өдөр “Улаанбаатар марафон-2024” Нийслэлийн Засаг даргын захирамжаар гаргасан өдөрлөгийн хүрээнд Улсын Их дэлгүүрийн урд нээлттэй хаалганы өдөрлөгт оролцсон.

- 2024.05.30-нд ТАЗ-с zoom-р “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг төрийн албан хаагч зөрчихөөс урьдчилан сэргийлэх нь” сэдвээр Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, Мэдээлэл арга зүйн газрын дарга Д.Баяндүүрэн сургалт явуулав
- 2024.06.06-нд ТАЗ-с zoom-р “Төрийн жинхэнэ албан хаагчийг томилох үйл ажиллагаанд гарч буй зөрчил” сэдвээр Төрийн албаны зөвлөлийн Маргаан хянан шалгах газрын дарга Ч.Бат-Эрдэнэ явуулна. Мөн Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн сургалт явуулав.
- 2024.06.10-ны өдрөөс эхлэн 10 удаа төрийн албаны зөвлөлөөс гаргасан шийдвэрийн дагуу УНДЕГ-аас зохион байгуулсан монгол бичгийн zoom-ээр явуулсан сургалтанд хамрагдсан.
- 2024.09.24-нд ЧДНДГ-с зохион байгуулдаг ээлжит Live-д оролцож иргэд даатгуулагчдад мэдээлэл зөвлөгөө өгсөн

ТАНИЛЦСАН: ХЭЛТСИЙН ДАРГА:

З.МӨНХНАРАН

ТАЙЛАН БИЧСЭН: ТЭТГЭВРИЙН ТОГТООЛТ,

ОЛГОЛТ ХАРИУЦСАН БАЙЦААГЧ:

Б.УУГАНЦЭЦЭГ